



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 11 сарын 14 өдөр

Дугаар 2/85

Бат-Өлзий сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.6 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавралтаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам” –ын 4.3.8 дахь заалтыг ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бат-Өлзий сумын 3 дугаар багийн Наймаа булангийн хошууны хэжлэгийн зам засварын ажил, Мойлтын булгийн эх хаших, Их Мойлтод мал тарилгын хашаа барьсан ажлын гүйцэтгэлийг тус тус хүлээн авах ажлын хэсгийг дараахь бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга: Н.Орхонтуул (Засаг даргын орлогч)

Гишүүд: С.Төмөр (3 дугаар багийн Засаг дарга)

Э.Дашдулам (Төсөв төрийн сангийн мэргэжилтэн)

Г.Бүд (Засаг даргын Тамгын газрын нярав)

Э.Буянтогтох (Хөдөө аж ахуйн тасгийн
мэргэжилтэн)

2. Захиалагчийн техникийн тодорхойлолт, шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа байдлыг хянан үзэж, гэрээний шаардлагыг биелүүлсэн нөхцөлд акт үйлдэж хүлээн авч танилцуулахыг ажлын хэсгийн дарга (Н.Орхонтуул)-д даалгасугай.

3. Орон нутгийн өмчид бүртгэх шаардлагатай хөрөнгийг өмчид бүртгэж, ашиглалт, хамгаалалтанд байнгын хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Ч.Батдулам), өмч хамгаалах байнгын зөвлөлийн дарга (Э.Дашдулам) нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.АМГАЛАН